

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

(2012 оны эхний 4 сард)

I. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 3.5 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө нь 90.9 хувиар давж биелсэн байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.4 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна. Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 2.3 тэрбум төгрөг болсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 21.1 хувиар дээгүүр гүйцэтгэлтэй байна.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр ХААН, Хас, Хадгаламж, Голомт банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 35.3 тэрбум төгрөгт хүрсэн нь оны эхнээс 0.2 тэрбум төгрөгөөр өссөн байна. Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн үлдэгдэл 21.5 тэрбум төгрөгт хүрч, оны эхнээс 4.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Мал аж ахуй: Оны эхний төллөх эх малын 66.8 хувь болох 603.3 мянган эх мал төллөж, гарсан төлийн 99.5 хувь болох 605.2 мянган төл бойжиж байгаа нь урьд оны мөн үеэс 84.6 мянгаар дээгүүр байна. Оны эхний малын 0.5 хувь болох 9.7 мянган мал зүй бусаар хорогдож, малын онд оролт 99.5 хувьтай байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 12.1 тэрбум төгрөг болж, урьд оны мөн үеийнхээс 2.5 тэрбум төгрөгөөр дээгүүр байна. Оны үнээр 43.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 3.7 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна. Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, хэвийн боов, ганбургер, нүүрс, цайрын баяжмал зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлт урьд оны мөн үеэс дээгүүр үзүүлэлттэй байна.

V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний үнийн индекс 4-р сард өмнөх сарынхаас 0.4 хувь, оны эхнээс 5.5 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 15.7 хувь, 2010 оны зэрэгцүүлэх үнээс 17.4 хувиар өслөө. 2012 оны 4 сард оны эхнээс 5.5 хувиар өссөний дотор хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн дүн 8.7 хувь, тээврийн бүлгийнх 11.8 хувь, зочид буудал, нийтийн хол, дотуур байрны үйлчилгээний бүлгийнх 17.4 хувиар нэмэгджээ.

VI. ЭРҮҮЛ МЭНД: Оны эхний 4 сард 429 эх амаржиж, 433 хүүхэд төрсөн нь өнгөрсөн оны мөн үетэй адил байна. 1 хүртэлх насандаа 11 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс 7 хүүхэд буюу 36.4 хувиар нэмэгдсэн байна. Халдварт өвчнөөр 203 хүн өвчилсөн нь урьд оны мөн үеэс 12-оор олон байгаа бөгөөд гепатит, салхинцэцэг, тэмбүү, трихомоноз зэрэг өвчлөлтүүд өссөн байна.

VII. АЖИЛГҮЙЧҮҮД: ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1556 болж, өнгөрсөн оны мөн үеэс 481 хүнээр өссөн байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 67.3 хувь нь 15-34 насны залуучууд байна. Боловсролын түвшинээр авч үзвэл 17.2 хувь нь дээд, 4.5 хувь нь тусгай дунд, 45.6 хувь нь бүрэн дунд, 5.7 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна. Эхний 4 сард 285 хүн шинээр бүртгүүлж, 198 хүн ажилд орсны дотор шинэ ажлын байранд 151 хүн ажиллаж байна.

VIII. ГЭМТ ХЭРЭГ: Оны эхний 4 сард 75 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 2-оор дээгүүр байна. Гэмт хэргийн улмаас 7 хүн нас барж, 23 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 53.4 сая төгрөгийн хохирол учирсны 50.4 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 62 хүн холбогдон сэжиглэгдсэний 29 хувь нь согтуугаар, 11.3 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 1197 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеэс 245 хүнээр олон байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 47 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

